



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 оны 12 сарын 03 өдөр

Дугаар 214

Мандалговь

“Дундговь-Ус” ОНӨУГазрын төлөөлөн удирдах

зөвлөлийн гишүүд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “а” Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дундговь аймгийн орон нутгийн 100 хувийн өмчит “Дундговь –Ус” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт орон нутгийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

ТУЗ-ийн дарга : С.Түвшинжаргал / СЦ сумын Засаг даргын орлогч /

Гишүүд : М.Баянсан / СЦ сумын Засаг дарга /

С.Дэжид / ИТХ-ын төлөөлөгч /

Г.Пүрэвжав / ИТХ-ын төлөөлөгч /


Ж.Мөнхтөр / ИТХ-ын төлөөлөгч /

А. Оюун / нягтлан бодогч /

Н.Мэндсайхан / ИТХ-ын төлөөлөгч /

2. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2009 оны 05 сарын 29-ны өдрийн 64 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3. Орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэхдээ Төрийн болон орон нутгийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрээр батлагдсан журам, удирдамж, зааврыг мөрдөж ажиллахыг ТУЗ-д даалгасугай.



ДАРГА

С.БУДЖАВ

0100000539